



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/214/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayaq@audit.gov.mn</p> <p>Аудитор Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022 о. 18 № 1302/137

төвийн _____ -ны № _____ -т

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 325 ДУГААР АНГИЙН
274 ДҮГЭЭР ТУСГАЙ САЛБАРЫН
ЗАХИРАГЧ М.БАЯНБИЛЭГ-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мян.төг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,637.96	73,391.18
35	БАРАА МАТЕРИАЛ	81,637.96	73,391.18
351	Түүхий эд материал	39,400.01	47,140.25
35110	Тусгай зориулалттай материал	38,296.39	45,428.12
35130	Эм боох материал	492.37	1,100.87
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,445.26	800.34
354	Хангамжийн материал	30,712.69	17,465.59
35410	Бичиг хэргийн материал	413.86	200.93
35420	Аж ахуйн материал	110.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	443.20	443.20
35440	Түлш, шатах тослох материал	8,792.25	249.64
35450	Барилгын засварын материал	5,508.65	5,508.65
35460	Хүнсний материал	14,985.73	10,618.18
35470	Бусад хангамжийн материал	459.00	445.00
35600	Мал амьтад	5,080.00	7,985.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	502,573.53	900,613.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	502,573.53	900,613.57
392	Биет хөрөнгө	475,665.53	873,705.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	108,167.68	190,735.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,986.27	-30,838.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,086.67	33,086.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-26,808.67	-31,878.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	0.00	3,564.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,684.79	1,684.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,684.79	-1,684.79
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	383,206.12	709,035.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,861.39	4,861.39
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,861.39	-4,861.39
393	Биет бус хөрөнгө	26,908.00	26,908.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,908.00	26,908.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	584,211.49	974,004.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	500.00
413	Өглөг	0.00	500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	584,211.49	973,504.75
51	Засгийн газрын хувь оролцоо	584,211.49	973,504.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337,562.35	337,562.35
51101	Өмч: - төрийн	337,562.35	337,562.35
512	Хуримтлагдсан үр дүн	191,145.33	580,438.59
51210	Өмнөх үеийн үр дүн	191,145.33	191,145.33
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	389,293.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,503.82	55,503.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	584,211.49	974,004.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	832,899.11	1,482,267.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,217.62	565,021.37
120	Нийтлэг татварын бус орлого	43,217.62	565,021.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,217.62	555,418.37
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,639.46	2,982.87
120004 5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,578.16	552,435.50
120009	Бусад орлого	0.00	9,603.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,681.49	917,246.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	789,551.49	917,076.24
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	789,551.49	917,076.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130.00	170.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	130.00	170.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	816,641.08	984,701.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	816,641.08	984,701.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,262.67	761,149.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,408.07	571,998.65
210101	Үндсэн цалин	361,805.66	362,804.61
210102	Нэмэгдэл	174,088.59	175,643.07
210104	Урамшуулал	35,513.82	33,550.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,351.09	23,798.09
210201	Тэтгэврийн даатгал	11,231.52	10,098.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,321.35	1,117.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,047.01	894.33
210204	Ажилгүйдлийн даатгал	261.75	223.58
210205	Эрүүл мэндийн даатгал	11,489.47	11,463.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,828.46	20,607.44
210301	Гэрэл, цахилгаан	3,833.47	4,773.88
210302	Түлш, халаалт	4,904.99	15,833.56
210303	Цэвэр, бохир ус	90.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,111.94	11,013.13
210401	Бичиг хэрэг	324.75	812.93
210402	Тээвэр, шатахуун	11,510.40	8,339.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250.00	150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	779.50	1,310.50
2105	Нормативт зардал	79,885.65	97,709.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	145.24	472.00
210502	Хоол, хүнс	72,900.75	81,390.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,839.66	15,847.37
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2,560.88

**Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	0.00	2,560.88
2107	Томилолт, зочны зардал	0.00	500.00
210702	Дотоод албан томилолт	0.00	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,677.46	32,962.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,119.20	8,504.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300.88	10,535.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,257.38	13,921.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,378.41	223,551.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,395.74	223,298.41
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,840.00	21,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,502.46	146,536.92
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,053.28	55,761.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,982.67	253.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,982.67	253.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,258.03	497,565.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	370.00	108,272.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	108,272.50
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	370.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-370.00	-108,272.50
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,888.03	389,293.26

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мян.төг/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,562.35	55,503.82	191,145.33	584,211.49
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,562.35	55,503.82	191,145.33	584,211.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,562.35	55,503.82	191,145.33	584,211.49

**Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	389,293.26	389,293.26
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,562.35	55,503.82	580,438.59	973,504.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ мян.төг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	792,629.04	920,229.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,947.56	2,982.87
120	Нийтлэг татварын бус орлого	2,947.56	2,982.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,947.56	2,982.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,947.56	2,982.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	789,681.49	917,246.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	789,551.49	917,076.24
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	789,551.49	917,076.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	130.00	170.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	130.00	170.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	792,629.04	920,229.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	792,629.04	920,229.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	698,250.63	696,677.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,408.07	571,998.65
210101	Үндсэн цалин	361,805.66	362,804.61
210102	Нэмэгдэл	174,088.59	175,643.07
210104	Урамшуулал	35,513.82	33,550.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,351.09	23,798.09
210201	Тэтгэврийн даатгал	11,231.52	10,098.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,321.35	1,117.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,047.01	894.33
210204	Ажилгүйдлийн даатгал	261.75	223.58
210205	Эрүүл мэндийн даатгал	11,489.47	11,463.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,017.47	12,064.83
210301	Гэрэл, цахилгаан	3,833.47	4,773.88
210302	Түлш, халаалт	10,094.00	7,290.95
210303	Цэвэр, бохир ус	90.00	0.00

**Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	12,410.40	9,289.70
210402	Тээвэр, шатахуун	150.00	600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,510.40	7,839.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250.00	150.00
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,933.60	78,855.90
210502	Хоол, хүнс	0.00	450.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	74,933.60	78,405.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130.00	170.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,378.41	223,551.94
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	92,395.74	223,298.41
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,840.00	21,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,982.67	253.53
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,982.67	253.53
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ мян.төг /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,887.20	919,805.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,887.20	919,805.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	696,588.80	696,507.17
210101	Үндсэн цалин	571,998.70	571,998.65
210102	Нэмэгдэл	362,804.61	362,804.61
210104	Урамшуулал	175,643.07	175,643.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,551.02	33,550.98
		23,879.60	23,798.09

210201	Тэтгэврийн даатгал	10,098.45	10,098.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,117.91	1,117.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	894.33	894.33
210204	Ажилгүйдлийн даатгал	223.58	223.58
210205	Эрүүл мэндийн даатгал	11,545.33	11,463.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,064.90	12,064.83
210301	Гэрэл, цахилгаан	4,773.90	4,773.88
210302	Түлш, халаалт	7,291.00	7,290.95
2104	Хангамж, бараа материалын зардал	9,289.70	9,289.70
210401	Бичиг хэрэг	600.00	600.00
210402	Тээвэр, шатахуун	7,839.70	7,839.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150.00	150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700.00	700.00
2105	Нормативт зардал	78,855.90	78,855.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	450.00	450.00
210502	Хоол, хүнс	78,405.90	78,405.90
2107	Томилолт, зочны зардал	500.00	500.00
210702	Дотоод албан томилолт	500.00	500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223.30	223.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	223,298.40	223,298.41
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,000.00	21,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	146,536.90	146,536.92
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55,761.50	55,761.49
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	919,887.20	920,059.11
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	917,076.40	917,076.24
131001	Улсын төсвөөс санхүүжих	917,076.40	917,076.24
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,810.80	2,982.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,810.80	2,982.87

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		170.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		170.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		170.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		170.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		170.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		170.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170.00
------	-----------------------------	--------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн, аудитор Б.Жалбаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн Н/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбар нь чиг үүргээ “Эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал мөн” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 1,482,267.6 мянган төгрөгийн 1 хувь буюу 14,822.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 10,375.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	81,637.90	73,391.20	-8,246.70
Үндсэн хөрөнгө	502,573.50	900,613.50	398,040.00
Нийт хөрөнгө	584,211.40	974,004.70	389,793.30
Өр төлбөр	0	500.00	500.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	584,211.40	973,504.70	389,293.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	584,211.40	974,004.70	389,793.30

Бараа материал дансны үлдэгдэл 73,391.2 мянган төгрөг болж буурсан нь түлш шатлах тослох материал болон хүнсний материалын өмнөх оны үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 974,004.7 мянган төгрөг болж өссөн нь элэгдлийн зардал болон дараах хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой байна.

- ✓ Бусад анги байгууллагаас 434,102.1 мянган төгрөгийн батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмж, 82,568.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 3,564.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсан
- ✓ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 108,272.5 мянган төгрөгийн батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмжийг шилжүүлсэн зэрэг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 500.0 мянган төгрөг болж өссөн нь шатахууны өглөг үүссэнтэй холбоотой. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 973,504.7 мянган төгрөг болж өссөн нь нь хуримтлагдсан үр дүн 389,293.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 919,887.2 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 917,076.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,810.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 917,076.2 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,982.9 мянган төгрөгийн, нийт 920,059.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 919,805.6 мянган төгрөгийг зарцуулж, 253.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэхүү буцаан төвлөрүүлэлт нь үндсэн үйл ажиллагааны орлогын давсан хэсэг болон тайлант онд хэмнэгдсэн зардлын зарцуулаагүй үлдэгдэл байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 170.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь туслах үйл ажиллагааны орлого байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тусгайлан авч үзэх асуудал ажиглагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбарын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох тээвэр шатахуун, хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс нууцын чанартай 7 төрлийн 84 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах шаардлагагүй, үлдсэн мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Итгэл” үзүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Аудитаар илэрсэн дараах зөрчлийг системийн хэмжээнд шийдвэрлүүлэхээр YAГ-г санал хүргүүлж байна.

1. Албан хаагчдад тооцсон сахилгын шийтгэлийн орлогыг өөрийн орлогоор бүртгэж, бусад зардалд зарцуулсныг зориулалт бус гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй байна.

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан шаардлага өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Зөвлөмж

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗХ-ний 325 дугаар ангийн 274 дүгээр тусгай салбар										



АУДИТОР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕРИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

БОЛОВСРУУЛСАН:

[Signature]
Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

[Signature]
Д.БАТ-УНДРАА

[Signature]
Г.ЗАЯА

2022.02.21